

**“Хөхнуурын чуулганы цааз”-ын
тухай анхны шинжилгээ**

Х.Цэрэнбал (Хөхнуурын үндэстний дээд
сургууль)

Агуулгын товч. Өгүүлэлд шинэхэн олдсон “Хөхнуурын чуулганы цааз бичиг”-ийн эх бичгийн байдал, агуулгын төлөв тойм, зохиолгогч, зохиогч, зохиогдсон он, эмхэтгэн дэвтэрлэгч, эх авсан бусад монгол, төвд цаазтай холбогдох холбоо жич өвөрмөц онцлог хийгээд үнэ цэнийг шинжлэн өгүүлнэ.

Зангилааны үг. “Хөхнуурын чуулганы цааз”, эх бичиг, агуулга, зохиолгогч, зохиогч, зохиогдсон он, эмхэтгэгч, харилцаа холбоо, өвөрмөц онцлог, үнэ цэнэ.

“Хөхнуурын чуулганы цааз” хэмээх энэхүү бичиг бол урьд өмнө улсын дотоод гадаадын эрдэмтэн мэргэдэд ерөөс мэдэгдээгүй Монголын эртний хууль цаазын дурсгал бичгийн нэг болно. Тус цааз бичиг бол дөрвөн ойрадын хошууд аймгийн Гэгээн Гүүш хан 1637 оноос хойш аймаг албатаа дагуулан Хөхнуур Төвдийн өндөрлөгт орж ирээд 48 жил болсны дараа 1685 онд Хөхнуурын чуулган дээр тунгаан батлагдсан цааз бичиг болно. Тус цааз бичиг нь “Алтан ханы цааз”, “Монгол Ойрадын цааз бичиг”, “Халхын долоон хошууны цааз”, “Төвөд цааз” зэрэг дөрвөн цааз бичгийг эх болгон лавлаж, тухайн үеийн Хөхнуурын дээд монголчуудын нийгэм түүхийн онцгой хувьсалт, улс төрийн шинэ байдал, аж ахуйн бодьтой нөхцөлд зохицуулан “нэмэлтийг нь нэмж, хасалтыг нь хасаж” /1/ байгаад шинээр найруулан баталсан цааз бичиг болно. Энэ цааз бол түүнээс өмнө зохиогдсон монголчуудын цааз бичигтэй удам гарлын нягт холбоотой мөртлөө төвд цаазтай ч салшгүй холбоотой байж, тухайн үеийн Хөхнуурын монголчуудын улс төр, аж ахуй, шашин шүтлэг, соёл, зан заншил, хууль цааз зэрэг нийгмийн амьдралын олон талаас нэлээд өргөн хамран тусгасан өвөрмөц онцлог бүхий орон нутгийн чанартай хууль цаазын бичиг болно.

НЭГ. "Хөхнуурын чуулган цааз"-ын олдвор ба агуулгын төлөв тойм

Тус хууль цаазын дурсгал бичгийн эхийг миний бие 1997 оны 1 сард одоогийн Хөхнуур мужийн Улаан шианы данс эвхмэлийн товчооны Д.Мөнх нөхрөөс олсон юм. Тус цааз бичиг бол гадар хавтасыг хөх ёрог бүсээр гадарлаж, нийтгэсэн хонины ноосоор үдэж дэвтэрлэжээ. 23,7x18,4 см хэмжээ бүхий давхарлан наасан цайвтар шар өнгийн цаасан дээр үсгийн хэв ба тиг зурлага нь жигд тодорхой, хулсан үзгээр бичсэн эх дэвтэр болно. Уг эх нийт 64 нүүр, 32 хуудастай, нэг нүүр нь 10 мөрөөр жагсаагдсан байна. Эдүгээ манайд олдсон энэ эхийн өмнө хэсгийн 44 нүүр, 22 хуудас нь урагдаж шатаад тасархай тамтархай хэсэг л үлджээ. Сүүлийн хэсгийн 20 нүүр, 10 хуудас нь бүрэн бүтнээрээ байна. Тус цааз бичиг чухал бүхий газар усны нэр, ихэс ноёд лам хувилгаадтай холбогдсон нэр цол, жич иш татсан ном судрын нэр, хууль цаазын зүйл зурвасын ялгал зэргийг улаан хулсан үзгээр онцлон тодорхойлж бичснийг гаргавал бусад агуулгыг цөм хар бэхээр хулсан үзгээр бичсэн байна.

Тус цаазын бичгийн өмнө хэсгийн урагдаж шатагдсан тамтархай тасархай хэсгийг эвлүүлж нийлүүлж үзвэл энэ цаазын бичгийн ерөнхий тойм агуулгыг их төлөв гаргаж болмоор байна. Тус цааз бичгийн оршил хэсэг, Далай лам Гүүш хааны зохиосон цааз болон Хөхнуурын чуулганы цааз зэрэг гурван үндсэн агуулгаас бүрэлдсэн төлөвтэй.

Нэгдүгээр хэсэг: Оршлын хэсэг: Энэ хэсгийн агуулгыг 1-12-р нүүр хүрчээ. Энэ хэсгийн нэгдүгээр нүүр дээр ямар ч үсгийн ул үлдээсэнгүй. 2-р нүүрийн эцсийн мөрийн сүүл дээр "...орны харанхуйн эвдэж" гэсэн хэдхэн үсэг үлджээ. Гуравдугаар нүүрийн эхний мөрд "бурханы цагаан гэрлийг сайтар өргөгч далайн давалгаа мэт өнгөрөн өг..." гэж, тус нүүрийн хоёрдугаар мөр дээр "...жувга ярун тивийн лянхуа..." хэмээх хэсэг үг өгүүлбэр үлджээ. Дөрөвдүгээр нүүрний эцсийн мөр дээр "...эгмийн хүчээр өөрийн болгон эрхэндээ оруулж. Ма...", тавдугаар нүүрийн эхний мөр дээр "...-ын чадагч баатар Сэрхэг бат зоригт Сэцэн хан тэргүүтэн нарны", зургадугаар нүүрийн эцсийн мөрт "...эдэлмой эс бөгөөс хүрд орчуулагч хаан болмуй хэмээн. Олдомилал", долдугаар нүүрийн эхний мөрт "...үрээр болохын олон вангаридад магтан сайшаагдахуй. Сансар зэрдэм". Наймдугаар нүүрний эцсийн мөрөнд "...оруулж, эд баригчийн охиноор хүсил ханахын хэвэл дүүрсэн мэт", есдүгээр нүүрний эхний мөрөнд "хамаг газрыг ер хүслээ дүүргэж, улмаар эд баригч тив ариун орон", тус нүүрийн хоёрдугаар мөрний эхэнд "-тур хүрч төвд орны Думда Лхас хувилгааны ...", тус нүүрний гуравдугаар мөрийн эхний хэсэгт "нарны садан лугаа ялгалгүй. Зоу ши...", тус нүүрийн дөрөвдүгээр мөрийн эхэн хэсэгт "мэт нигүүлсэхүй нэгнээ хураа...", тус нүүрийн тавдугаар мөрийн эхэн хэсэгт "хамгийг мэдэгч Базар дара...", тус нүүрийн зургадугаар мөрийн эхэнд "тамга хүндийн...", тус нүүрийн долоодугаар мөрний эхэнд "-аар хэм /кам ишлэгчээс/ орон" зэрэг нэлээд арвин үсэгтэй. Аравдугаар нүүрийн эхнээс хойш дөрөвдүгээр мөрийн эхэнд "...бядыг эрэг т..." цааш тавдугаар мөрийн эхэнд "омдүгэ эвдсэн...", зургадугаар мөрийн эхэнд "Дөрнө гүмбийн бүх орон...", долдугаар мөрийн эхэнд "Зарлан хаан хоёрын эрхэнд эс...", наймдугаар мөрийн эхэнд "барин, өмнө энэтхэгийн дээд өвсийн бэл..." есдүгээр мөрийн эхний хэсэгт "Амдогаас дээш ахудахаар хамаг газраа эрх яван...", аравдугаар мөрөнд "ертөнцөд өвчин тахалгүй насаар уртад имигсэний /нэмсний/

сайн бэлгэс олж", арван нэдүгээр нүүрийн эхний мөрөнд "хоёрдугаар Төгс бүрний баясгалангийн юримыг барагдашгүй эдлэхүй эдүгээ цагт", тус нүүрийн хоёрдугаар мөр "төвдийн цаазын бичиг урьд болсноос...", арван хоёрдугаар нүүрийн эцсийн мөр дээр "ияан буюу..." гээд энэ хэсгийн агуулга төгсч, хойшго нэг мөрийн хэртэй хоосон зай үлджээ.

Энэ хэсгийн агуулгыг дээрх алдаг оног үг өгүүлбэрүүдээс мөрдөж үзвэл, төвд орны шашин төрийн мандал хөгжлийн улирал хувьсал жич Гэгээн Гүүш хааны Хөхнуур, Төвдийн өндөрлөгийн Кам, Андо, Төвд зэрэг бүх Төвдийн гурван орныг эрхшээлдээ оруулж хаан суугаад, Энэтхэг Непалын хаадаас алба барих болсон түүхэн гавьяа зүтгэлийг магтан сайшааж "баясгалангийн хуримыг барагдашгүй эдүгээ цагт" төвдийн урьдын хууль цаазыг өөрилж засварлах чухалтай болсон зэрэг агуулгуудыг багтаасан төлөвэй, иймээс энэ хэсэг бол тус цааз бичгийн оршлын хэсэг болох нь нэлээд тодорхой мэдэгдэж байна.

Хоёрдугаар хэсэг. Гүүш хааны цаазын бичгийн агуулга, 13-р нүүрээс 23-р нүүр хүртэл

13-р нүүрийн эхэн дээр "их төрийн тусад гэм хийгсэдийг засаглах" гэж улаан өнгийн хулсан үзгэр эхлээд 23-р нүүрийн эхэн дээр "буяныг /-ы -эрхлэгчээс/ цаазаар амыан огоот төгссөн төгөлдөр цогийг өөрсдөө эдлэхийн сайн хууль нээв. Тэхил өглөгийн эзэн наран саранаас хослон барилдсан бурхан...ялангуяа ялгуусан эрхэт" гэх мэтсийн хагас дутуу гурван мөр өгүүлбэр байдаг. Дээр ярьснаас гадна энэ хэсгийн дотор "эвдвээс улсыг нь авая.." "ноёд сайд түшмэд. Нэгдүгээр хамагт...", "төрийн тулд. Амиа хайрлалгүй ...байж шагнах бай.", "таван морь ав...", "нэг морь ав...", "дуун хураах гал нуу..." гэх мэтийн үгс алдаг оног үлдсэн байна. Ялангуяа тус хэсгийн 17-22 хүртэлх нүүрийн үсэг бүрмөсөн урагдсан болохоор агуулгын тойм төлвийг төсөөлөхөд тун бэрхтэй болжээ. Гэвч дээрх "өөрсдөө эдлэхийн сайн хууль нээв" гэсэн болон залгаад гарах өглөгийн эзэн Гүүш хаан болон ялгуусан эрхэт Далай ламын нэр цол дурдагдсан байдал болон тус цаазын төгсгөл дэх "энэ цаазын эхэн дээр Далай ламын зохиосон зарлиг болсон шажныг баригч номын хааныхаар хийсэн цааз бичиг найруулагд" /2/ гэдэг хэсэг өгүүлбэртэй холбож үзвэл ээ хэсэг бол даруй далай ламын зарлигаар Гүүш хааны хийсэн цаазын агуулга байсан бололтой.

Гуравдугаар хэсэг. "Хөхнуурын чуулганы цааз"-ын агуулга 2362-р нүүр хүртэл

23-44-р нүүр хүртэл уягдаж тасран тамтархай болжээ. 23-р нүүр буюу 24-р нүүрийн аль нэг хэсгээс "Хөхнуурын чуулганы цааз"-ын бодитой агуулга эхэлсэн бололтой. Энэ хэсгийн алдаг оног, хэсэг бусад мөрүүдийн үг өгүүлбэрийг эвгүүлж үзвэл, гэвш, гавж, гэлэн, гэцэл, банди нарыг дайрах, занчих буюу алваас түшмэл хийгээд тугчин бүрээчний цаазтай адилаар шийтгэх, хин алсан хэрэгт хуучин сорви байх эсэхийг хянах, ял хийснийг төмөр улийтгаад шарж, ам өчгийг нь авч, юм авбаас гөрчтэй авах, гар хөл эздэрсэн, шүд хугалсан, эрхий долоовор хугалсанд ор авч торгох. Эцэг эхэд гэжээл тасалсныг шийтгэх, мал хулгайлж унаваас хөл морь авах, хөлтос Зүү галд сүсэглэхээр ирснийг хааж санд хийхийг шийтгэх, нэгжүүлийн тухай зэрэг агуулгууд алдаг оног барагдаж байдаг. Иймээс хамгийн наадам нь энэ хэсгийн цаазын агуулгад шаардлага

суртахууны тухай, эрүү өчгийн тухай, гэрч баримтын тухай, биеийн эрхтэнг гэмтээсэн тухай, эцэг эхэд тэжээл таслагсдын тухай, хол аянчны замын саадын тухай, нэгжүүлийн тухай зэрэг цаазын агуулгыг багтааж байсан нь бүүр түүр мэдэгдэж байна. Энэ хэсэгт өөр бас ямар ямар хэргийн тухай цаазын агуулга байсан нь тодорхойлахуйяа бэрхтэй болжээ.

Тэгвэл 45-62 хүртэлх хэсэг бол одоогоор манай үед бүрэн бүтнээр үлдэж ирсэн цаазын хэсэг болно. Энэ хэсгийн агуулгыг тус цаазын зүйл ангилж хуваасныг үндэслэн нийт 14 зүйл хувааж болно.

1. Улаа элчийн зүйл: Тус хэсгийн эхлэлт нь урагдаж тасарсан болохоор "улаа элчийн зүйл" хэмээх тусгай нэрийдэл байхгүй, гэвч агуулгыг нь үндэслэн улаа элчийн зүйл гэж хуваав. Үүнээс ноёд ламын улаа элчийн тухай, яамт яамгүй элчийн тухай, бэрх хийсэн хүний тухай, хуурмаг элчийн тухай, эд малын бүтээлгийн тусад явагч элчийн тухай, улс нүүлгэгч элчийн тухай зэрэг цаазын агуулгуудыг багтаажээ.
2. Ер босуулын зүйлд: харьд гарах хүн, хүч үл хүрэх босуул, айл зуур явах босуул, их гэмт босуул, босуулыг үл зарлан нууж саад хийгсэд, гэм багатай босуул, гаднаас ирэх босуул, хариас ирсэн босуулын тухай, босуулыг алдсан, зохицсон, дарсан зэрэг ял хийгсэдийн тухай, эрээ голсон эм, ноёноо голсон боолын тухай, хүн хуурч оргуулсан тухай, урвасан хүний тухай цаазын агуулгыг багтаажээ.
3. Ер худал хэлсэн зүйлд: Их улс өргөөд нутгийг худал хэлж үймүүлэн нүүлгэсэн тухай, ноёд, хадууд, сайдын хооронд буюу ерийн хүн хоорондоо хов хэлсэн тухай, ноёдын зарлиггүй хуурч юм авсан тухай, хов үгэнд үнэн худлын гэрчийн тухай, хуурмагаар ноёны нэрийг хэрэглэх тухай зэрэг цаазын агуулгууд багжээ.
4. Зарын зүйлд: Гадаад дотоодын тухай дайсны тухай зар, мордох цэргийн зар, хулгайчийн тухай зар, авын тухай зар, золбин малын тухай зар, хонины ноосны тухай зар, гар дахь зулбан завхарсан тухай зар, хөсрөөс олсон юмны тухай зар, галзуу нохойн тухай зар зэрэг цаазын агуулгыг багтаажээ.
5. Эндэхүйн зүйлд: дайсан зүгт хүн эндүүрч алсан тухай, хүргэгсдийн зүгт хүн ташаарч алсан тухай, ноён хан хүн нирваан болсон тухай, харц хүн үхсэн тухай, халдварт өвчинтэй хүн халдвар тараасан тухай зэрэг цаазын агуулгыг багтаажээ.
6. Арилжаа худалдааны зүйлд: хоёр талын худалдан авах зарчмын тухай, хуурч сольж худалдсан тухай, өвчтэй малыг мэхэлж худалдсан тухай, гадаад дотоодын тангад монгол түнш нар чиглүүр, жин, шинж суулгыг ёсноос гадна хийсэн тухай, цай тамхийн багцыг хасаж худалдсан тухай, хоёр хүний дунд худалдааг дааж авсан хүний тухай зэрэг цаазын агуулгыг багтаажээ.
7. Өрийн зүйлд: их ноёны өрийн тухай, бага ноёны өрийн тухай, хурим дээрх өрийн тухай, болгосон идээ сааль шим буюу унасан хөлсний тухай, асарч үржүүлсэн хүүхдийг эцэг эх нь авах тухай, хүний гэр дэх боолын тухай зэрэг цаазын агуулгыг багтаажээ.
8. Ер сүйн зүйлд: Хан хүний сүйн тухай, их бага ноёдын хорин нас хүрээгүй хүүхний сүйн тухай, гэрчтэй ба гэрчгүй сүйн тухай,

ноёдын гэргийн ба хүүхэнтэй явалцсан тухай, хорь насалсан хүүхний тухай, сүйгүй хүүхэнтэй явалцсан тухай, эртэй эмтэй явалцсан тухай, хөнжил татсан, өлөг тасалсан, хөх барьсан, үнэссэн тухай, эргүй эмийг хүчилсэн тухай, хоёр хүн нууцаар зохицолдсон тухай, хүн адгуус малтай явалцсан тухай, хүний эхнэрийг оргуулсан тухай, нөхөр нь ялд одсон сүйтэй хүүхний тухай зэрэг цаазын агуулгыг багтаажээ.

9. Түймрийн зүйлд: Түймэр алдаж юм түлсэн тухай, зориуд түймэр тавьсан тухай, түймэр унтраасан хүний тухай, түймэр унтраахад саад болсон тухай зэрэг цаазын агуулгыг багтаажээ.
10. Усны зүйлд: Уснаас хүнийг аварсан тухай, бороонд зуссан малын тухай, чоно хөөсөн малыг аварсан тухай зэрэг цаазын агуулгыг багтаажээ.
11. Буруу үзэлт бөө удганы тухай: Гэртээ бөө удганыг бөөлүүлж удгалуулах тухай, үзсэн хүний тухай, онгодтой хүний тухай, онгод булаалдсан тухай зэрэг цаазын агуулгыг багтаажээ.
12. Хоноцын зүйлд: Улс дун дявагч хүнд хоног үд өгөх тухай цаазын агуулгыг багтаажээ.
13. Ном бичиг сургах зүйлд: Арван наснаас хүүхдэд ном бичиг сургах тухай, цагаан сарын 1-30 хүртэл эзэнгүй амьтаныг үл алах тухай цаазын агуулгыг багтаажээ.
14. Ач тус хүргэхүйн зүйлд: Эцэг эхийг хүндэлж үгээс үл гарах тухай, эцэг эхийг буруугаар загнах, гар хүрч амаар дайрч зөв бурууг үйлдэгсэдийг өмчөөс нь торгох тухай, хан хүний хайрласан хүн, эзний үйлд санаж хичээсэн хүнийг эндэлгүй хайрлах тухай зэрэг цаазын агуулгыг багтаажээ.

Дөрөвдүгээр хэсэг. Цаазын төгсгөлийн үг 62-63-р нүүр хүртэл

Энэ хэсэгт тус цаазад багтаасан агуулга, цаазыг зохиоход эх авсан цаазууд хийгээд нэмж хассан тухай жич хэний зарлигаар хэн хэзээ, ямар чуулган дээр, ямар хүмүүсийн оролцоогоор батлаж тунгаасан зэрэгт тодорхойлолт хийжээ.

**ХОЁР. "Хөхнуурын чуулганы цааз"-ын зохиолгогч,
зохиогдсон он, зохиогч дэвтэрлэгчийн тухай шинжлэл**

Нэг. Зохиолгогч ба зохиогдсон оны тухай

Тус цаазын төгсгөлийн үгэнд "Далай тайж эхлэн хэсэг ноёны зарлигийн ёсоор" "дээд дөрвөн эхэд энэ цаазын бичиг модон үхэр жилийн Хөхнуурын чуулган дээр. Эрдэнийн далай хун тайж эхлэн их бага ноёд лам нар сайд түшмэд. Бүхэл хэвлэж шүүж тогтоов. Өлзий хутаг оршив" /3/ гэж тэмдэглэсэн байна. Тэгвэл энд дурдагдаж байгаа тус цаазыг зохиолгохоор зарлиг буулгасан хэсэг ноёдын түрүү болох "Далай тайж" буюу "Эрдэнийн далай хун тайж" хэмээгч чухам хэн болох вэ гэдэг асуулт аяндаа гарч ирнэ. Хөхнуурын монголчуудын тухай тэмдэглэсэн түүхэн сурвалж бичгийг шүүж үзвэл, дээд монголчуудын түүхэн дээр дээрх хоёр нэр цолтой адилаатар буюу ойролцоо ноёдын нэр хэд харагдах боловч энэ мэт зарлиг буулган цааз зохиолгож Хөхнуурын чуулган дээр шүүн батлуулж чадах эрх сүртэй хүн харин цөөн байсан юм. Гэгээн Гүүш хааны Төвдийн орны хаан суусан тухай "Усан морин жилийн /1642/ хоёрдугаар сарын 25-ны өдөр, бүх баруун төвдийн модон үүдтэн бүгдээрээ оморхог

сурталаа огоорч, Гүүш хааныг хүндэтгэн биширч толгой бөхийн мөргөж шударгачилан дагав. /Цагийн хүрд/-ийн анхдугаар жилээр он сар тэмдэглэснийг үндэслэж, 3-р сарын мөрөөдөлт өдөр бүх Төвдийг бүрмөсөн нэгтгэх үйлсээ биелүүлж, бүх Төвдийн гурван орны хаан суув" /4/ гэж тавдугаар Далай ламын "Залуусын хурим"-д тэмдэглэсэн байдаг. Тэгвэл Гүүш хаан арван хөвгүүнтэй билээ. Хятад түүхэн сурвалж бичиг "Монголчуудын малжил нүүдлийн тэмдэглэл"-ийг үндэслэвэл, Гүүш хаан "ууган хөвгүүнээ томилж, түүний олноо захируулан Далай баатраар туслагч болгожээ" /5/ гэсэн тэмдэглэл байдаг. Энэ тухай Габан Ширэвийн зохиосон "Дөрвөн ойрадын тууж" хэмээх монгол сурвалж бичигт "Гүүш хаан Их жигших /Даян очирт-ишлэгчээс/ хөвүүндээ Төвд нийтээрийнхээ ноён хийгээд өмч эс өгөв. Далай хун тайжид нийтийг өгөв. Далай хун тайж /би гагцаар юун гэж идэв. Би төрөлдөө хувааж өгөв/ эцэг хаан нүднээс нулимс гаргаж үүнийг минь Далай лам хайрлах буй/ гэв" /6/ гэж тэмдэглэжээ. Энэ хоёр зохиолд дурдагдаж байгаа "Далай баатар" буюу "Далай хун тайж" гэдэг нь даруй Гүүш хааны зургадугаар хөвгүүн Дорж далай баатар болно. Тухайн үед Дорж далай баатар нь Хөхнуурын бүгд захирагч ноён байж, Хөхнуур дахь найман тайжийн түрүү болдог байв. Тэр Гүүш хаанаас олгосон өмчөө ах дүү найман тайждаа хувааж өгсөнөөс тухайн үеийн түүхэн сурвалж бичигт "Хөхнуурын найман тайж" /7/ гэж алдаршсан бөгөөд энэ нь "Найман тайжийн дүрэм" болон тогтоод 1723 онд Лувсанданзан Манж Чинийг эсэргүүцэн зэвсэгт тэмцэл гарах хүртэл оршсоор байжээ. Дорж далай баатар нь тухайн үедээ зөвхөн Хөхнуурын бүгд захирагч ноён төдийгүй хошууд хаант гөрийн ордноос туслагчийн хувиар Чин улсын Эээр засагч хааны хоёрдугаар он /1645/ ба гуравдугаар он /1646/-д Гүүш хааны байгуулсан их төрийг төлөөлөн Чин улсын Засгийн газарт "айлтгал өргөн" "алба барьж" гадаад харьцаа байгуулж байсан тухай "Чин улсын үнэн хуульт бичиг" /8/-д тэмдэглэлтэй байдаг. Мөн "Зая бандитаны тууж Сарны гэрэл" –д Хөхнуурын тайжуудын тухай ярихдаа "Далай тайж тэргүүлэн их бага ноёд" /9/ гэж тэмдэглэж байдаг. Иймээс энэ цаазын бичиг "Далай тайж тэргүүлэн хэсэг ноёдын зарлигийн ёсоор" гэсэн үгийн доторх "Далай тайж" бол Гүүш хааны зургадугаар хөвгүүн Хөхнуурын бүгд захирагч ноён Дорж далай баатарыг зааж байгаа нь тодорхой байна. Энэ тухай улам лавшруулж батлах баримт гэвэл Чин улсын Энхамгалангийн 14-р он /1675/-ы 4-р сарын хөхөгчин туулай өдрийн тэмдэглэлд "элч томилон Далай тайжид бичиг илгээн, аймгаа захирч, хилийн аюул битгий гаргатугай хэмээн мэдэгдвэй" /10/ гэсэн байх бөгөөд Энхамгалангийн 13-р он /1674/-д Хятад оронд Эү Шан Хүйн урвалт гарсанд Хөхнууртай холбоо байгуулахын төлөө "Далай тайжид бэлэг хүргэн зам харилцааг холботугай" /11/ гэсэн тэмдэглэл ч байдаг. Дорж баатарыг тухайн үед дотоод гадаадгүй цөмөөрөө "Далай тайж" хэмээн дөхөмчлөн цол өргөсөн байдаг тухай бид дээр дурдсан монгол хятад түүхэн сурвалж бичгээс баримт олж болно. Тэгвэл модон үхэр жилийн Хөхнуурын чуулган дээр энэ цаазыг шүүж батлан хэвлэхэд оролцсон "Эрдэнийн далай хун тайж" хэмээгч чухам хэн бэ гэвэл миний үзэхээр энэхүү Хөхнуурын бүгд захирагч ноён Дорж далай баатар болно. Гүүш хаан нас барсны дараа Даян очирт хааны үед Тавдугаар далай ламаас Доржид "Далай хун тайж" хэмээх цол өргөсөн байна. Иймээс түүхэн зарим сурвалж бичиг дээр "Дорж далай баатар хун тайж" гэж нэрлэх удаа харагддаг билээ. Энд "Далай хун тайж"-ийн өмнө "Эрдэнэ" гэсэн цол нэмж тавьсан нь Тавдугаар далай ламын өргөмжлөлтэй холбоотой бололтой. Тухайлбал 1640 онд тогтоосон

"Монгол-Ойрадын цааз бичиг"-т Цоросын баатар хун тайжийг "Эрдэнэ баатар хун тайж" гэж бичсэн байдаг. Энэхүү "эрдэнэ" хэмээн цолыг 5-р Далай ламаас Цорос баатар хун тайжийн шарын шашныг тэтгэсэн гавьяа зүтгэлийнх нь хариуд олгосон цол болно гэж тус номын тайлбарт тодорхойлжээ. Үүнээс үзвэл 5-р Далай ламаас өргөсөн цолын өмнө "эрдэнэ" хэмээх цол авч товойлгодог ёс заншил тухайн үе нэлээд дэлгэрч байсан бололтой. Дорж далай хун тайж Энх амгалангийн 29-р он /1690/-д нас баржээ. 1691 оны эхээр түүний ой гашуудлын ёслолыг Рашилунбү хийдэд өвтэгш ихээр хийжээ. /12/ Энэхүү өвтэгш ой гашуудал нь тухайн үеийн Хошууд хаант төрийн дотор Дорж далай баатарын нэр хүнд байр суурь хэр зэрэг өндөр байсныг харуулж байх юм. Энэ байдлаас үзэхэд тус цаазыг батлан тогтоосон "модон үхэр жилийн Хөхнуурын чуулган дээр" Дорж далай хун тайж Хөхнуурын бүгд захирагч ноён болох гол тушаалтны хувьд оролцох нь зүй ёсны хэрэг билээ. Жаран жилээр нэг эргэдэг төвдийн равжунгийн тооллоор бол энэхүү "модон үхэр жил" нь нийтийн он тооллын 1685 онд ноогдоно. Энэ Дорж далай хун тайж нас барахаас 5 жилийн өмнөх хэрэг болох бөгөөд Гүүш хааны дагуулгаар ирсэн Хошууд монголчууд Хөхнуурт нутаглаад 48 жил болсны дараах учир болно. Энэхүү Хөхнуурт ирсний дараах хагас зуу шахам жилд Монголчуудын нийгэм түүх, улс төрийн байдал өдий төдий шинэ хувиралт, гарч, шинэ орчин тойрны бодитой ахуйдаа зохицуулан "нэмэлтийг нэмж, хасалтыг хассан" орон нутгийн онцлог бүхий шинэ цааз зохиох нь ч түүхэн зайлшгүй шаардлагаар тавигдсан зүйл болсон нь гарцаагүй юм.

ХОЁР. Зохиогч ба эмхэтгэгчийн тухай

Монголчууд хууль цаазыг аль эртнээс зохиож ирсэн баялаг уламжлалтай бөгөөд хууль цаазаар төр засч ирсэн шилдэг удамшилтай үндэстэн болно. Аль эрт 13-р зууны үеэс хойш Чингисийн "Их засаг", Хубилай сэцэн хааны зохиосон гэдэг "Арван буянт номын цагаан түүх", Түмэн засагт хааны "Их цааз", "Алтан хааны зарлиг цааз", "Монгол Ойрадын цааз бичиг", "Халх долоон хошууны цааз", "Галдан хун тайжийн захиа зарлиг", "Халх журам" гэх мэтийн их бага цаазыг удаа дараагаар зохиож, төр гүрэн аймаг угсаагаа төвхнүүлж ирсэн түүхтэй юм. Гэтэл эдгээр өөрийн төрөлх хэлээрээ зохиогдсон хууль цаазын бичиг нь хэний зарлигаар зохиолгосоныг ихэд чухалчлан дурдаж, цаашилбал зохиолгосон хүнийг зохиогч болгон нэрлэж, цаазын бичгийг жинхэнэ гардан найруулж зохиосон хүний нэр цол, газар усыг тодорхой тэмдэглэдэг зүйл бараг харагддаггүй. "Арван буянт номын цагаан түүх" мэтийн хааяа зарим хууль цаазын бичгийн сүүлчээр ордосын Хутагт сэцэн хун тайж "Бэлгэтэйеэ сайтар барилдуулж шинжлэн бичвэй" /13/ гэдэг боловч үнэндээ Хутагт сэцэн хун тайж бол уул зохиогч биш мөртөө засвар оруулж сэлбэсэн найруулагч ч биш, харин адил бусын хоёр эхийг "шинжлэн бичсэн" эмхэтгэгч л төдий юм. Иймээс монголын эртний зонхилох хууль цаазын бичгүүдэд тухайн үеийн тэдгээр ноёрхогч ангийн хаад ноёдын эрхэм цол л түүх сударт үлдэн хоцорч, хожмын хүмүүст алдаршин дуурсаад жинхэнэ оюуны хүч хөдөлмөрөө зориулсан найруулан бичигч буюу зохиогч нь түүхэн хуудаснаас гээгдэж балархайдах буюу үгүйсгэгдэн булагддаг байсан юм. Энэ нь хууль цаазын бичиг нь тухайн үеийн ноёрхогч ангийн эрх ашгийн төлөөний багаж хэрэглүүр болж байсныг харуулах төдийгөөс биш, үнэнхүү оюуны хөдөлмөрийг зарцуулсан эрдэмтэн мэргэдийн хувь хүний гавьяа

зүтгэлийг балласан шинжтэй юм. "Хөхнуурын чуулганы цааз" бол одоо хүртэл манайд мэдэгдэж байгаа монгол хууль цаазын бичгүүдийн дотор, хамгийн анх тодорхойгоор оюуны хөдөлмөрийг зарцуулсан хувь хүний нэр цолыг зүй ёсоор тэмдэглэн тавьсан хууль цаазын сурвалж бичиг болох юм. Энэ тухай тус цаазын бичигт "эд бүгд цаазын бичгээс шилбэж /сэлбэж-ишлэгчээс/ зүйтэйг нь оруулагд-өөрийн санаснаар өчүүхэн нэмэлтийг нь нэмэгд. Далай тайж эхэлж хэсэг ноёны зарлигийг ёсоор Сгхрбудын Рдува Рзе Дабан Хүгийн хийсэн дээд дөрвөн эхт энэ цааз" /14/ гэж тодорхой тэмдэглэл үлдээжээ. Энэхүү төгсгөлийн тэмдэглэлээс бид энэ цаазыг найруулан зохиогч бол "Сгхурбуду" хэмээгч газрын "Доржвандуг" гэдэг монгол төвд бичигт мэргэшиж нэвтэрсэн эрдэмтэн хүн болохыг олж мэддэг байна. Миний бие "Сгхрбуду" хэмээгч чухам хаана байгаа газар болох, Доржвандуг гэдэг хүн тухайн үедээ ямар гарал түүхтэй хүн байсныг энд нарийн сүвэгчилж үл амжсан болохоор цаашид нягтлан судлууштай ажил болгон үлдээв. Дагалдуулан тушаагууштай зүйл гэвэл тус цаазын нэрийг "Дөрвөн эхт энэ цааз бичиг" гэж төгсгөлийн үгэнд дурджээ. Гэтэл халх монголд Чин улсын үед бас "дөрвөн эхт цааз" гэж тогтоон зарласан цааз байдаг болохоор тус цаазын агуулгыг үндэслэн "Хөхнуурын чуулганы цааз" гэж нэрлэснийг тодорхойлоё. Уул цаазын эхний нүүр тасарсан болохоор чухам ямар нэртэй байсан нь тодорхойгүй.

Тус цаазын эмхэтгэгчийн тухайд бол энэ цаазын хамгийн сүүлийн нэг цаас илүү гарсан нүүр дээр "Бүрэнт засагчийн арван нэгдүгээр он зургаан сарын шинийн хоёр" гэсэн хэдэн үсэгтэй бөгөөд тус цааз бичгийн дэвтрийн арын хавтасны дотор нүүрийн цаасан дээр "тавдугаар дэвтэр бичиг" гэсэн хэдэн үсэгтэй. Энэ хоёр нүүрэн дээр тэмдэглэсэн хулсан үзгийн үсгийн тиг нь өмнөх гол агуулгын хэсгийн үсгийн тигтэй баахан ялгаатай мөртлөө бэхний өнгө нь өмнөх хэсгийн үсгийн бэхний өнгөөс шингэвтэр байдаг. Үүнээс гадна гол агуулгын доторх зарим үгийн хажуугаар хааяа зарим үгийн засалт буюу нэмэлт оруулсан зүйл харагддаг. Тухайлбал: уг эхийн " эс барив гэм"-ийг "бариваас" гэж, "зуур явах босуул" гэсэн хэдэн үгийн өмнө "айл" гэсэн үг нэмж "авав гэм нь" гэснийг "авбаас", "тавив гэм" гэснийг "тавиваас", бичэч" гэснийг бичээч", "арваан" гэснийг "арван", "хийд" гэснийг "хид", "үгүй ши" гэснийг "өгшиг", "газарт" гэснийг "газар таны" гэх мэтээр хажуугаар нь засч бичсэн байдаг. Эдгээр хажуугаар зассан үсгийн бэхний өнгө нь шингэвтэр бөгөөд "Бүрэнт засагчийн арван нэгдүгээр он..." гэсэн үсгийн тигтэй адил хэвтэй байна. Энэ бол яг Бүрэн засагчийн 11-р он /1872/-ы үеийн эмхэтгэгчийн хажуугийн засалт болох нь илтэд мэдэгэж байна. Иймээс манай үед уламжлагдан ирсэн энэхүү эх дэвтэрийг 1872 онд ямар нэгэн бичгийн хүнээс судар номуудыг дугаарлан дэвтэрлэж эмхэтгэх үедээ "тавдугаар дэвтэр бичгийн" эмхэтгэл болгож оруулсан бололтой. Энэ тухай доорх мэтийн хэдэн баримтаар цаашид нотолж болмоор юм. Юуны урьд энэхүү эмхэтгэгчийн амьдарч байсан цаг болох 1872 он болоход, дээд монголчуудын хэл ярианы онцлогт нэлээд хувиралт гарч, зарим нэг ойлгомж муутай болсон эртний хэллэгийг эмхэтгэгчээс хажууд нь засалт үг тавьж онцлон тодорхойлох оролдлого хийжээ. Гэхдээ эмхэтгэгчээс уг эхэд нь үнэнч байхыг чанга зорьж тун хянамгай овор засалт авсан нь илэрхий харагдаж байна. Үүнээс үзвэл уг эх бол 17-р зууны сүүлчийн үеийн дээд монголчуудын хэл яриа ба үсгийн бичлэгийн онцлогийг хадгалсан эх болно гэж үзэх баримттай байна.

Дэдэд нь нотлох баримт бол "хаан, хан, хун тайж, их бага ноёд, сайд түшмэд, тугчин, бүрээчин, их төр, яамт яамгүй элч, зангийн эзэн, дэмч дарга" гэх мэтсийн нэр цол энэ цаазад харагдахаас биш, харин Чин улсаас монголын ноёдод өргөмжилсөн "чин ван, жиюн ван, бэйл, бэйс, улсын түшээ гүн, улсын туслагч гүн, тэргүүн зэргийн тайж" гэх мэтсийн цол өргөмжлөл ер нэг ч харагдахгүй байна. "Хөхнуурын чуулганы цааз" зохиогдоод 13 жил болсны дараа 1697 оны сүүлчээр Хөхнуурын бүгд захирагч ноён Дашбаатар тэргүүтэй хошууд тайж нар Бээжинд очоод манжийн хаанд бараалж, 1698 оны хоёр сард Чин улсын төрөөс Дашбаатарт анх чин ван хэргэм олгож, бусад дагалдан очсон хошууд тайж нарт бэйл, бэйс, туслагч, гүн, тэргүүн зэргийн тайж зэрэг хэргэм цол олгожээ. /15/ Хэрэв энэ цааз бичиг сүүлчээр зохиогдсон буюу дахин засагдаж найруулагдсан бол Чин улсаас өргөмжилсөн зэрэг хэргэмийн нэр цол ямар нэг хэмжээгээр тусгал олох ёстой юм. Гэтэл ийм зүйл өчүүхэн ч харагдахгүй байна. Энэ нь тус цааз нь уг эхийн ёсоор хадгалагдан уламжлагдаж ирсэн болохыг нь давхар нотолж байна.

Гуравт. Тус цаазын бичиг нь үсэг зүй ба бичлэгийн онцлогийн талаар 17-р зууны үеийн хулсан үсгийн хуучин бичгийн онцлогийг нэлээд тод хадгалж байдаг. Тухайлбал, үеийн дунд тохиолдох "ц" (c), "ж" (j) болон "и" (i) "е" (y) зэрэг үсгийн дүрсийн яг адилхнаар бичсэн байна. Жишээлбэл, "цаачин" /цаазан/, "зулцахан" /зулзаган/, "занчибаас" /занчибаас/, "жанбарчила" /ямарчлан/, "зохицуцу" /зохицож" гэх мэтийн үгсийн бичлэг дээр тодорхой илэрнэ. Сонирхолтой нь үгийн эхэнд "е" (y) ба "ж" (j)-г хэлбэрийн хувьд адилхан бичдэг боловч "ж" толгойн өмнө дусал тавьж "е"-гээс ялгадаг байна. Тухайлбал, "жахарамжи" /яарамж/, "jabdal" /явдал/, "jal" /ял/, "jeke" /их/ мэтээр бичигддэг байхад "ж"-ээр эхэлсэн үгийг "jangxi", "ja", "jui" гэх мэтээр олонх тохиолдолд ялгаж бичдэг байна. Чанга хүнд үгэнд ялгаж хэрэглэдэг "г" (γ), "г" (g) дэвсгэр үсгийг олонх тохиолдолд ялгаж хэрэглэсэн байтал хааяа хүнд чангыг хутгаж хэрэглэсэн "üjegülügen" /üjegülügen/, "endegüriügen" /endegüriügen/ мэтийн үсгүүд харагдана. Олонх тохиолдолд "гэ" /g/, "га" (γ)-ын дуслыг тавиагүй байтал үгийн эхэн, дунд, адагт тохиолдох "н" /n/-ын дуслыг бараг бүр алдалгүй тавьсан байна. Нөхцөл үйл үгийн "жу", "чу"-г ярианы хэлний онцлог бүхий "чи"-ээр тэмдэглэжээ. Зарим тохиолдолд харьяалахын тийн ялгал "-ы"-г гийгүүлэгчийн дараа орох заахын тийн ялгал "и" /i/-тэй адилаар тэмдэглэжээ. Тухайлбал, "nom-un kaan-i jarliu-iyar", "doluγan košikun-i saγaci" гэх мэтээр тэмдэглэжээ. Өгүүлбэр бүрийн утгыг салгасан буюу заагласан газар цөм давхар цэг тавьдаг. Ямар нэгэн хэсэг бүлгийн утга төгссөн газарт "---" тэмдэг бүхий төгсгөл цэгийг тавьж, олонхи тохиолдолд хоёр буюу гурвантаа давтан залгаж тавьдаг бөгөөд "---" иймэрхүү төгсгөл цэгийн дээд доод хөндлөн хоёр цэгийг хар бэхийн үзгээр тавьж, дундах хөндлөн цэг болон зүүн баруун голдуу цэгийг улаан бэхийн үзгээр тавьж, дээр нь зүсээр үл дардаг нь их сонирхолтой өвөрмөц онцлогтой. Өгүүлбэр зүйн талаар охор авсаархан өгүүлбэр зонхи хэрэглэдэг. Энэ мэтийн үсэг зүй, зөв бичлэгийн тогтолцоо, цэг тэмдэг ба өгүүлбэр зүйн онцлог нь яг сайхан монгол сонгодог бичгийн хэлний зөв бичлэгийн дүрэмчлэл хараахан

тогтворжоогүй байсан 17-р зууны үеийн хуучин хулсан үзгийн дурсгал бичгийн онцлогийг их тодорхой тусгаж байдаг.

ГУРАВ. "Хөхнуурын чуулганы цааз"-ын өвөрмөц онцлог ба үнэ цэнэ
Нэг. "Хөхнуурын чуулганы цааз" хийгээд эх болсон гурван монгол
цаазын хоорондох харилцаа холбоо

"Энэ цаазын эхэн дээр Далай ламын зохиосон зарлиг болсон шажныг баригч номын хааны зарлигаар хийсэн цаазын бичиг найруулагад. Түүнд үгүй нь Алтан гэгээн хааны зарлиг цааз. Долоон хошуу дөрвөн ойрад цуглаж хийсэн цааз" Долоон хошууны цааз төвд цааз. Эдний бүгд цаазан. Бичгээс сэлбэж. Зүйтэйг нь оруулагд. Өөрийн санаагаар өчүүхэн нэмэлтийг нь нэмэгд" гэж тус цаазын төгсгөлийн үгэнд тодорхой бичсэн байдаг. Үүнээс үзвэл энэ цаазын бичиг нь түүнээс өмнө зохиогдсон монгол цаазын бичигтэй яахын аргагүй садан төрлийн харьцаатай байгаа нь тун илэрхий байна. Ялангуяа тус цаазын бичгийн агуулгыг тоймчлон үзвэл "Монгол-Ойрадын цааз бичиг"-тэй тун нягт холбоотой байгаа нь мэдэгдэж байна. Тухайлбал, "Монгол ойрадын цааз бичиг" /17/-ийн 22,23,42,50,57,58,68,70,75,109 зэрэг зурвасуудын агуулга нь бараг тэр янзаараа буюу бага сага өөрчлөлт хувиралттайгаар орсон байдаг. Мөн "Монгол-Ойрадын цааз бичиг"-т үл харагддаг "Халх долоон хошууны цааз" /даруй 1620 оны "Бичин жилийн их цааз"/ /18/ ын 72-р зурвас, "Алтан хааны цааз" /19/-ын 74-р зурвасын агуулга ч харагдаж байна. Үүнээс гадна нэлээд хэсэг зурвасын агуулга нь тус гурван цаазад нийдэм дурдагдаж байдаг агуулга байдаг. Гэвч "Хөхнуурын чуулганы цааз" бол дээр дурдсан эх авсан гурван монгол цаазын хуулбар буюу ерөнхий эмхэтгэл огт биш юм. Харин тухайн үеийн Хөхнуурын нийгэм түүхийн шинэ хувиралтын байдалд зохицуулан "нэмэлтийг нь нэмж хасалтыг нь хасч" зохиосон орон нутгийн өвөрмөц онцлог бүхий биеэ даасан хууль цааз болох нь тодорхой байна. Энэ цаазын эх авсан дээрх монгол цаазуудын харагдаж байгаа харавчийн тухай, өдөр тутмын аар саар эдлэл хэрэгсэлийн тухай, бэдэргээн тухай, зарт саалийн тухай, инж дагуулах тухай, уралдааны морины тухай зэрэг цаазын агуулга нь манайд олдсон тасархай тамтархай буюу бүтэн хэсгээр үлдэж байгаа энэ цаазын агуулгад ер харагдахгүй байдгийг үзвэл, нийгэм түүхийн шинэ нөхцөлд зохицуулан эдгээр агуулгыг хассан болов уу хэмээх төрөгдөл өгдөг. Гурван монгол цаазаас эх авсан хэсгүүд ч гээд олонх байдал доор эдгээр цаазын гол зарчмаас ул авч мөрдөөд цааш тухайн бодитой байдалтайгаа уялдуулан зарим агуулгыг нарийсган дэлгэрүүлж, зарим агуулгыг товчлон хасч, зарим агуулгыг нь өөрчлөн зассан байдаг. Тухайлбал элч улааны тухай агуулгад өмнөх хэсэг нь үндсэндээ эх авсан гурван монгол цаазын агуулгатай их төлөв төсөөрхөг байхад, энэ агуулгын сүүл дээр "яамтай яамгүй хэн ч боловч өөрийн явсан үйлийн тусад харь халуунд хэлэлцэх үгтэй болов. Гэмийг илгээгч эзний нэрийг үл хугарахын цагт харихаа зөв зүйгээр олж хэмээгд. Явсан үйлээ бүтээхүйн аргаар хичээх хэрэг буй. Ял бүтээхэд явагч элч болбал. Авч өгөх ёс мэдэх хэрэгтэй" /20/ гэж бичсэн байдаг. Иймэрхүү агуулга эх авсан гурван монгол цаазад ер харагдахгүй байдаг. Энэ нь тухайн үеийн "харь халуун" үндэстэн ястан холилдон суусан, газар нутаг өргөн уудам, зам нэвтрүүлэг дөхөмгүй Хөхнуур төвдийн өндөрлөгийн бодитой ахуйгаас үүсч, нэлээд

амьдлаг чөлөөтэй тогтоосон хууль цаазын тогтоол болох нь илтэд мэдэгдэж байна. Энэ маягийн нөхвөр нэмэлт буюу хасалт тус цаазын агуулгын зүйл буюу зурвасын дотор цөөн бус харагдаж байна. Цаашилбал эх авсан гурван цаазад байхгүй шинэ агуулгууд ч цөөн бус харагдаж байдаг. Тухайлбал худалдаа арилжааны тухай, ном бичиг сурах тухай, эцэг эхээ ачлах тухай зэрэг агуулгын зүйлүүдийн зарим нь энэ цаазаас өмнөх монгол цаазад ер харагдахгүй цоо шинэ агуулгууд байна. Тухайлбал худалдаа арилжааны тухай агуулга даруй ийм байдаг. Ном бичиг сурах тухай зүйл болон эцэг эхээ ачлах тухай агуулга тус цаазаас сүүлээр зохиогдсон зарим монгол цаазын /21/ дотор харагдах боловч агуулгын талаар эрс ялгаатай болсон байдаг. Эдгээр төвд цаазын нөлөө тусгал юмуу, эсвэл монгол үндэстний цаазын шинэ хөгжил хувиралыг харуулсан зүйл болох юмуу гэдгийг одоохондоо тас нотлол хийхэд бэрхтэй ч цаашид улам нягтлан судлууштай асуудал болно.

Хоёр. "Хөхнуурын чуулганы цааз" хийгээд төвд цаазын хоорондох харьцаа холбооны асуудал

Хөхнуурын дээд монголчууд 1637 онд Хөхнуур төвдийн өндөрлөгт орж ирээд төр гүрэн байгуулж явахдаа эндхийн төвд үндэстэнтэй зах залгаа холбоо нутаглан сууж, улс төр, шашин шүтлэг, аж ахуй, хууль цааз, соёл боловсролын талаар туйлын нягт харилцан холбоо үүссэн юм. Ойрадын гэгээн Гүүш хаан 1637-1642 он хүртэл Хөхнуур төвдийн өндөрлөгийг бүрэн эрхшээлдээ оруулах явцад тэр 1640 онд ойрад нутгийн Тарвагатайд болсон ойрад халхын ихэс ноёдын чуулган дээр хүрч, алдарт *"Монгол-Ойрадын цааз бичиг"-ийг* тогтооход оролцсон байна. /22/ Тэр энэ удааны чуулганд оролцоод буцаж ирмэгц 1643 онд Төвдийн уул цааз бичгийг өөрчилж шинээр цааз тогтоов. Гүүш хааны тогтоосон энэхүү цааз нь тус *"Хөхнуурын чуулганы цааз бичиг"-ийн* эхэн дээр найруулагдан орсон тухай энэ цааз бичгийн төгсгөлийн үгэнд тодорхой тушаалт хийсэн байна. Харамсалтай нь манай үед уламжлагдан ирж чадсангүй. Энэ тухай Хөхнуур монголын түүхэн сурвалж бичигт *"Цанбаг дарсанаас хойш, Төвдийн хууль нь монгол хууль ёсыг дагадаг болжээ. Тэгээд монголын чанга хатуу хуулийн ёсоор төвдийн хууль ч маш чанга хатуу болсон билээ"* /23/ гэж тэмдэглэжээ. Дээд монголын эртний түүхч Ванчинжавын тэмдэглэснийг үндэслэвэл *"Гүүш хааны хуулийн бичигт: Баатар идтэний зурвас, аймтгай хулжины зурвас, хүн алсан ялын зурвас, хулгай дээрмийг торгож төлүүлэх зурвас, шалиг самууныг шийтгэх зурвас, худал үнэнийг ялгах зурвас, айлган сүрдүүлэх зурвас, ялтаныг баривчлан хүлэх зурвас, торгон залхаах зурвас, нутгийн ноёд түшмэдийн зурвас, нутгийн ноёд түшмэдийг залхаах зурвас, ноёд түшмэдийн ордон харш идээн умдааны зурвас, хүн шархдуулсныг торгох зурвас, гол ялтаныг шийтгэх зурвас, ураг салахыг шийтгэх зурвас, шөнө дундаар цаг ялгах зурвас, хүний гол эрхтэнийг гэмтээсэн тухай зурвас"* /24/ зэрэг арван долоон зүйлийн агуулгатай гэж гарчиглан тэмдэглэсэн байна. Дээд монголын нөгөө нэг түүхч Аман бандида Гончигчоймбол түүний түүхэн номдоо *"урьд Пагва лам төвдийн гурван чолгийг эрхшээж байхдаа явуулж байсан арван гурван зурвас хууль нь хятадын хуулийг үндэслэсэн юм байлаа. Төвдийн Цанба хааныг*

дарсны дараа Өглөгийн эзэн /Гүүш хааныг заажээ-ишлэгчээс/ болон өглөгч /тавдугаар Далай ламыг зааж-ишлэгчээс/ даруй арван гурван зурвас хууль дээр Панруй болон Санба Риндэн Цанба тэргүүтэний /Цагийн хөгжлийн алтан чимэг/ Ринбуны Агваанчиграг тэргүүтний /Цагийн хөгжлийн бүжиг/ зэрэг агуулгыг оруулж, монголын хуулийг үндэслэн тогтоов" /25/ гэж тэмдэглэсэн байна. Эдгээр сурвалж бичгийн тэмдэглэлээс Гүүш хаан монголын хууль цаазаар үндэслэл болгож, төвдийн урьдах хууль цаазыг лавлалт болгон тухайн үед төвд оронд хэрэгжүүлэх шинэ хууль цааз тогтоосныг тодорхой олж харах болно. Зөвхөн дээр дурдсан Гүүш хааны цаазын гарчигаас үзсэн ч "Монгол Ойрадын цааз бичиг"-ээр үндэслэл болгож төвдийн урьдах цаазад өөрчлөлт хийсэн нь бүүр түүр харагдаж байдаг. Тэгвэл "Хөхнуурын чуулганы цааз"-д төвдийн ямар ямар нэртэй цаазыг хэрэглэгдэхүүн болгож лавлаж ашигласан тухай тодорхой дурдсангүй. Бид дээр дурдсан Аман бандида Гончигчоймболын ном дэх төвд цааз болон бусад төвд бичгээр тэмдэглэгдсэн цаазыг олж, агуулгыг эрэн харьцуулал хийж чадсангүй болохоор санаа тааваараа энэ тэр гэж таамаглахад бэрх боловч хэлбэрийн талаасаа энэ цааз төвд цаазын нөлөөг хүртсэн нь зохих хэмжээгээр харагддаг байна. Энэ тухай доорх мэт хэдэн талаас ярьж болмоор байна.

Нэгд. Энэ цаазын эх болж ашиглагдсан гурван монгол цаазад агуулгын төрөл зүйл хуваан ангилсан байдал ер харагдахгүй байдаг. Гэтэл "Хөхнуурын чуулганы цааз" нь агуулгаа төрөл зүйл болгон хуваан ангилсан тодорхой ангилалтай байдаг. Тухайлбал, зарын зүйлд, гадаад дотоодын дайсны тухай зар, цэрэг мордох зар, хулгайчийн тухай зар, чуулганы зар, золбин малын зар, авын зар, хөсрөөс олдсон юмын зар, галзуу нохойн тухай зар гэх мэтээр зүйлд холбогдох агуулга бүхнийг нэг доор төвлөрүүлэн тусгаж, агуулгын хуваарь ангилалыг их тодорхой болгожээ. Энэ тухай тус цаазын манай үед уламжлагдан ирэхдээ бүтнээрээ үлдсэн хэсгээс үзвэл, арван дөрвөн зүйлийн агуулгын хуваарь ангилалтай тэмдэглэгдсэн нь тодорхой баримт болж байна. Иймэрхүү үзэгдэл энэ цаазаас өмнө бичигдсэн монгол цаазуудад харагдахгүй байдаг. Энэ цаазаас 24 жилийн дараа бичигдсэн "Халх журам"-д хэдийгээр "нэг зүйл, хоёр зүйл" гэх мэт хэлбэрийн хуваарь харагддаг боловч агуулгын талаар төрөлжүүлэн хуваасан үзэгдэл харагдахгүй байдаг. Иймээс энэхүү агуулгын талаар төрөлжүүлэн хуваарь хийсэн үзэгдэл бол төвд цаазын нөлөө ихээр хүртсэн үзэгдэл болох бололцоотой юм. Төвдчүүд эртнээс аваад цаазаа "Хүн болох номын арван зургаан ариун хууль", "Арван гурван зурвас хууль" гэх мэтээр төрөл хуваан нэрлэдэг байсан нь үүнийг дамаар гэрчилж байна.

Хоёрт. Тус цаазад төрөл зүйлийн хуваарийн ялгалын цөм ялган үсгээр тэмдэглэсэн мөртлөө цаазны дотор илэрсэн зарим ихэс ламын нэр цол, чухал газар усны нэр, цаазад ишлэсэн шашны ном судрын нэр зэргийг цөм улаан өнгөт хулсан үзгээр тэмдэглэсэн байдаг. Тэрчлэн "Лхас, Андо, Кам, гэцэл, банди, гэмбу, Сгхрбуду, Доржвандуг" гэх мэт газар ус буюу хүний зэрэг цолын хажууд төвд үсгээр тэмдэглэн тодорхойлжээ. Иймэрхүү онцлог нь тухайн үеийн төвд ном судар буюу төвдөөс орчуулагдсан монгол ном сударт ямагт харагдаж байдаг нэгэн зүйлийн үзэгдэл болно. Үүнээс үзвэл, эдгээр зүйлийн онцлог бол төвд

судар буюу төвд судрын орчуулгыг тэмдэглэх аргаас ирэлттэй нь илтэд харагдаж байна.

Гуравт. Тус цаазад цаазын агуулгын ямар нэгэн төрөл зүйлээр хуваасан хэсгийг тэмдэглэж барвал хойно нь заавал "Субашид", "Алтангэрэл", "Сайтар номлохуй эрдэнийн сан", "Аймгийн судрын чимэг", "Ангид тонилсон судар", "Далай лам Очирдарын зарлиг", "Дар чу хааны шаштир", "Арадын тийн ялгал залуугийн хоолойн чимэг" /26/ гэх мэт чухал судар номоос үг өгүүлбэрийн жишээ товчлон авч татаад, ногдож байгаа цаазын агуулгын зүй ёстой чанарыг баталдаг байна. Бодитой жишээгээр тодорхойлбоос: ерийн босуулын тухай агуулгыг бичиж бараад "Субашид"-аас: Худлаар хуураа хэмээн. Шийтгэхүл өөрийг хуурах мөн. Нэгэнтээ худал өгүүлсэн түүгээр үнэн өгүүлбээс сэрэл төрөх хэмээн зарлиг болсон мэт" /27/ гэж товч жишээ татан өмнөх цаазын агуулгыг зүй зохистой чанарыг нотолжээ. Иймэрхүү үзэгдэл одоо болтол олдоод байгаа манай үед уламжлагдан ирсэн бусад монгол цаазын бичигт нэг ч харагддаггүй юм. Энэ нь тус цааз төвд судар ном буюу цааз бичгийн бичлэгийн онцлогийн нөлөө хүртснийг хамгийн баттай тусгаж байна.

Хураангуйлж үзвэл "Хөхнуурын чуулганы цааз" бол одоохондоо улсын дотоод гадаадын эрдэмтэн мэргэдийн өмнө анх мэдэгдэж байгаа монгол эртний хууль цаазын чухал дурсгалт бичгийн нэг болно. Мөн ч Хөхнуурын дээд монголчуудын нийт монгол туургатаны эртний хууль цаазын хөгжлийн түүхэнд үзүүлсэн хувь нэмэр бүхий өв соёлын нэг болно. Тус цааз 1685 онд Хөхнуурын чуулган дээр Далай хун тайжийн зарлигаар шүүн батлагдаж тунхаглагджээ. Манай үед уламжлагдан ирсэн эх нь хэдийгээр хагас дутуу болсон боловч тухай үеийн хөхнуур монголчуудын улс төр, нийгэм байгуулал, аж ахуй, амьдралын заншил, соёл боловсрол, хууль цааз зэргийг ойлгож судлахад олтгойлж болшгүй ховор чухаг материалыг манайд хангаж өгчээ. Тэрчлэн "Алтан гэгээн хааны зарлиг цааз", "Монгол-Ойрадын цааз бичиг", "Халх долоон хошууны цааз" зэрэг монголын түүхэн дэх чухал цааз бичгүүд 17-р зууны сүүлч хүртэл Хөхнуур монголчуудын дотор уламжлагдан, шинэ хууль цааз зохиоход гар авлага болон ашиглагдаж байсан түүхэн үнэнийг баттай гэрчилжээ. Энэ нь дээрх монгол цаазуудын нийт монголчуудын дунд дэлгэрч тархсан хүрээ хэмжээ, "Хөхнуурын чуулганы цааз"-тай хэлхээ холбоо, жич 17-р зуун үеийн монгол цаазын түүхэн хөгжилт ба орон нутгийн өвөрмөц онцлог бүхий хөгжил хувирал зэргийг цаашид гүнзгийрүүлэн судлахад эрхэм нандин судлагдахууны үнэ цэнэтэй. Ялангуяа монгол үндэстэний хууль цааз төвд үндэстэний хууль цаазыг хэрхэн нөлөөлж байсан, төвд үндэстэний уламжлалт хууль цааз нь эргээд монгол үндэстэний хууль цаазын хөгжилд ямар шинэ агуулагдахууныг олгож байсан зэргийг судлахад сонирхолтой шинэ материалыг хангаж өгсөн байна. Үүнээс гадна, 17-р зууны үеийн нийт монголчууд хийгээд хөхнуурын монголчуудын үсэг бичиг, хэл ярианы онцлогийн харилцаа холбоог судлах үнэт материалыг манайд хангаж өгсний хувьд мөн чухал үнэ цэнэтэй байна.

Зүүлт

(1), (2), (3), (14), (16), (20), (26), (27) манайд олдсон "Хөхнуурын чуулганы цааз"-ын уг эхээс ишлэв. Үүнээс гадна тус өгүүллийн агуулгын төлөв тоймын хэсэг дэх хашилтанд жишээ авсан зүйлүүд бол цөм уг цаазын тасархай тамтархай хэсгээс жишээ авсан алдаг оног үг өгүүлбэр болохыг онцлон тодорхойлъя.

(4) Баясхал, Осор, Габи нарын найруулсан "Дээд монголын түүхэн сурвалж бичгүүд" дэх тавдугаар Далай ламын "Дөрвөн хаадын тэмдэглэл, төгс бадрангуй залуу насны баясгалант шувууны яруу дуулал"-аас ишлэв. Тус номын 346-р нүүрт лавла.

(5), (7), (12), (15) "Хөхнуурын монголчуудын товч түүх"-ийн хятад хэвлэлийн 133, 131, 132, 134, 149 зэрэг нүүрт лавла. Хөхнуурын ардын хэвлэлийн хорооны 1993 оны хэвлэлээс ишлэв.

(6) Алтаноргил нарын найруулсан "Ойрадын түүхийн сурвалж бичиг"-ийн 248-р нүүрт лавла. Өвөр монголын ардын хэвлэх хорооны 1985 оны хэвлэлээс ишлэв.

(9) "Рабжимба Зая бандидагийн түүж, Сарны гэрэл хэмээх оршвой", тод үсгийн "Хан тэнгэр"-ийн 1983 оны 4-р хугацааны 79-р нүүрт лавла.

(10), (11) "Чин улсын Шинцү хааны үнэн тэмдэглэл"-ийн 53-р боть болон 73-р ботьд лавла.

(13) Лиү Жин сүвэгийн эмхэтгэн тайлбарласан "Арван буянт номын цагаан бичиг", Өвөр монголын ардын хэвлэлийн хорооны 1981 оны хэвлэлийн 73-р нүүрт лавла.

(17) Н.Буян-Өлзий, Боу Гэ нарын харьцуулан тайлбарласан "Монгол-Ойрадын цааз бичиг" Өвөр монголын ардын хэвлэлийн хорооны 2000 оны хэвлэлээс ишлэв.

(18) Чигээгийн "Халхын долоон хошууны цаазын тухай товч танилцуулга" "Өвөр монголын нийгмийн шинжлэх ухаан" сэтгүүлийн 1990 оны 5-р хугацааны 22-30 нүүр хүртэл лавла.

(19) "Алтан хааны цааз"-ын хятадчилга, Өвөр монголын нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн түүх судлах газрын 1984 оны "Монгол түүх судлалын түүвэр"-ийн 173-182-р нүүр хүртэл лавла.

(21) Н.Буян-Өлзий Боу Гэ нарын харьцуулан тайлбарласан "Монгол-Ойрадын цааз бичиг" дэх "Донробраашийн нөхвөр зүйл"-д лавла. Өвөр монголын ардын хэвлэлийн хорооны 2000 оны хэвлэлийн 300-р нүүрт лавла. Эрдэмтдийн шинжилгээг анхаарбал "Донровраашийн нөхвөр зүйлийг" 1741-1761 оны хооронд тогтоосон гэж үздэг.

(22) "Монгол-Ойрадын цааз бичиг"-ийг үндэслэвэл, 1640 оны Тарвагатайн чуулганд оролцсон халх ойрадын 26 ихэс ноёдын дотор хошуудын Төрбайх ноёныг "Гүүш номын хан" гэж тодорхой тэмдэглэжээ.

(23), (24), (25) Баясхал, Осор, Габи нарын найруулсан "Дээд монголын сурвалж бичгүүд"-ийн 161,162,440-р нүүрүүдэд лавла. Лионингийн үндэстэний хэвлэлийн хорооны 1997 оны хэвлэлээс ишлэв.